



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/480

Булган сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмыг шууд дамжуулах Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Монголын мэдээ сувгийн сэтгүүлчдийг “Анаг” ХХК-ийн Анаг тур амралтын газарт байрлуулах, шаардагдах зардал 4,365,000 (дөрвөн сая гурван зуун жаран таван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Шаардагдах хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010630

2024 оны 07 сарын 01 өдрийн 4/480 тоот  
Захирамжийн хавсралт



**"АЛТАРГАНА-2024" ОЛОН УЛСЫН НААДМЫН ШУУД ДАМЖУУЛАЛТААР  
АЖИЛЛАХ БАГИЙГ БАЙРЛУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Үйл ажиллагааны нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Хоног	Нийт үнэ
1	МУОНРТВ-ийн сэтгүүлч	15	37000	3	1,665,000
2	Хоол	15	60000	3	2,700,000
<b>НИЙТ</b>					<b>4,365,000</b>